

ТАНАКА ГИЙЧИГИЙН МЕМОРАНДУМ*Б.Саранчимэг**

Танака Гийчи (1863-1929) нь Мэйжи, Тайшёо, Шёова гэх гурван засаглалын нүүр үзсэн Японы улс төрийн зүтгэлтэн, цэргийн хүн. Тэрээр 1863 онд одоогийн Ямагүчи аймагт төржээ. Хятадад цэргийн алба хаасны дараа Орост цэргийн атташегаар 4 жил ажиллаж, дараа нь Японы армийн жанжин штабт ажиллах хугацаандаа 1904-1905 оны Орос-Японы дайнд Японы талаас дайн зарлах явдалд тодорхой үүрэг гүйцэтгэжээ. 1915 онд дэслэгч генерал цол авч 1918-1921 онд Харагийн засгийн газарт Цэргийн яамны сайдын алба хашжээ. Тэрээр 1927 оны 4 дүгээр сарын 20-нд японы ерөнхий сайдаар томилогдон, ГЯЯ-ны сайдын үүргийг давхар гүйцэтгэх болов.

Японы улс төрийг Минсэйто ба Сэйюкай гэсэн хоёр хүчний нам атгаж байв. Минсэйто нам нь хятадын эх газрын талаарх “аядуу бодлого”, Сэйюкай ба Танакагийн нам нь Манжуурын эдийн засгийн асар их бололцоог эзэмших зорилго баримталж байсан ба Танака ерөнхий сайд болсноор, Японы зүгээс Хятадын талаарх бодлогод зарчмын өөрчлөлт гарах нь илэрхий болоод байв.

Гоминьданы арми Бээжин өөд умардын аянаа сэргээж, Бээжин-Тяньжиний районд тулж ирээд байлаа. Ерөнхий сайд болоод нэг сар ч болоогүй байсан Танака Гийчи гадаад бодлогын асуудалтай тулгарсан нь Сидэхарагийн бодлогыг залгаж, уг регионаас япончуудыг татаж гаргах уу, эсвэл эрс хатуу бодлого явуулж цэрэг илгээх үү гэдэг асуудал байлаа. Ингээд 1927 оны 5-р сарын 28-нд Циндаод 2000 цэрэг илгээх шийдвэр гаргав. Үүнтэй холбогдуулан Гоминьданы засгийн газар 6 дугаар сарын 1-нд эрс эсэргүүцэл илэрхийлэв.

Ийм нөхцөлд Танака Гийчи өөрийн засгийн газрын Хятадын талаарх бодлогыг зөвлөлдөн хэлэлцэх зорилготой Дорнодын асуудлаарх хурал гэдгийг Манжуур- Монголын асуудалд холбогдол бүхий иргэний болон цэргийн 100 орчим түшмэл- (ГЯЯ-ны орлогч сайд Мори, Азийн хэлтсийн дарга Кимура, Цэргийн яамны дэд сайд, Жанжин штабын орлогч Минами, Манжуурт буй японы эрх баригчид болох Квантуны захирагч Кодама, Квантуны армийн командлагч Муто, Бээжинд суугаа элчин сайд Ёшизава Кэнкичи, Мүгдэнд суугаа ерөнхий консул Ёшида Шигэруг.м.)-ийг 1927 оны 6 дугаар сарын 27-наас 7 дугаар сарын 7-нд зарлан хуралдуулав.

Дорнодын асуудлаарх уг хуралд хэлэлцэх асуудал нь Чан Кайшигийн умард зүгт хийж буй аян дайныг дэмжих эсэх, Манмо буюу Манжуур-Монгол дахь Японы онцгой эрх ашгийг хэрхэн яаж цаашид хамгаалах тухай байв.

* Б.Саранчимэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Танака нь Хятад, ялангуяа Манжуур-Монголын талаарх үйл ажиллагаа нь манай Японы эрх ашигт нийцэх эсэхийг нягтлах үүргийг Эзэн хаанаас авсны үндсэн дээр уг хурлыг хуралдуулж, энэхүү хурлаас гарсан шийдвэрт үндэслэн эзэн хаандаа өргөх бичиг барьсан гэдэг. Харин хожим тэр нь “Танака Гийчигийн меморандум” гэгдэн түүхийн тольноо тэмдэглэгдэн, түүх судлаачдын дунд маргаан хэвээр үлдсэн судалгааны томоохон сэдэв болсон юм. Асуудлын гол нь Танакагийн меморандум үнэн бодит зүйл байсан уу, зохиомол зүйл байсан уу гэдэгт юм. Өнөөг хүртэл Хятад, Тайваньд үнэхээр байсан гэж үздэг бөгөөд Европ, Америкийн зарим оронд ч энэ үзэл баримтлал хадгалагдсаар иржээ. Харин япончууд анхнаасаа няцаасан мэдэгдлийг хийж байв. Токиогийн олон улсын шүүх ч жинхэнээсээ байсан гэдгийг нотлох гэж оролдоод шүүх хурлын явцад нотлох аргагүй болмогц Японы милитаристуудын хамтын хуйвалдаан гэх үзэл баримтлалаас аяндаа ухарсан юм.

Мэйжигийн үеэс хойш, японы хүн ам өсч, өлсгөлөнд нэрвэгдсэн Япончуудад үүнээс гарах ганц гарц бол газар нутгаа өргөтгөх явдал байсан юм. Дөрвөн талаараа далайгаар хүрээлэгдсэн арлын япон нь Азийн эх газар луу чиглэсэн гадаад бодлого явуулж байв. Хятад бол Японы эхний зорилго байв. Хятадын гадаад дотоод байдал сул дорой байсан энэ үед 1931 оны 9 дүгээр сард Манжуур /хятадын зүүн хойд хэсэг/-ыг эзлэн авч, 1934 онд Манж-го хэмээх тоглоомын улс байгуулан олон улсад зарлан тунхагласан явдал Хятадуудын хувьд Танакагийн меморандум бодит үнэн зүйл байсан гэх үзэл баримтлал нь меморандумын дараахь хятад дахь японы бодит үйл ажиллагаатай шууд хамааралтай юм. 1932 онд олон улсын нэгэн хурал дээр Хятадын төлөөлөгч “Уг асуудлын хамгийн үнэмшилтэй баталгаа бол одоо Манжуурт Японы явуулж байгаа бодлого юм” гэж хэлж байжээ.

Танакагийн Меморандумын талаарх таамгууд

Японы түүхчдийн судалгаанаас үзэхэд Танакагийн меморандум зохиомол зүйл байсан гэдэг талаас нь илүү нотлохыг оролдсон судалгаа хийсэн байна. Дорнодын асуудлаарх хурлын тухай сонины материалыг ашиглан япон хүн юмуу эсвэл хятад хүн зохиосон эсвэл япон хүн анх зохиогоод хятад хүнд худалдсан байж болох талтай гэж үзжээ. Гэвч 1930-аад оны эхээр Танакагийн меморандум мэтийн зохиомол төлөвлөгөө Хятадад нэг биш хэд хэдэн хувилбараар тархаж байжээ. Тухайлбал, “Манж-Монголыг Японд нэгтгэх нууц төлөвлөгөө” гэгч нэртэй бас нэг баримт байсан байна. Такакура Тэцүүчигийн үзсэнээр тухайн үеийн улс төрийн намуудын хоорондын зөрчилдөөнөөс Минсэйто намынхан Сэйюкай намын нэр хүндийг унагаах зорилготой зохиосон гэж үзэж байна. Иноу Дэнтарогийн судалгаанаас үзэхэд “Мүгдэнд байсан гадаад бодлогын дугуйлангийнхантай холбогдол бүхий, Японд урьд өмнө нь

сурч байсан учир японы тухай нэлээдгүй мэддэг нэг хүн 1929 оны зун түүнээс хоёр жилийн өмнө болсон Дорнодын асуудлаарх хурлын тухай элдэв материал, мөн дурьдатгал гэсэн нэг багц материалыг /тавин мянган иенээр/ худалдаж авсан гэдэг ч яриа бий гэжээ. Мөн Хятадын цэргийн томоохон эрхтэн Жан Сюлянийн ойр шадар хүн Ван Зячэнийг энэ хэрэгт холбоотой гэж үзжээ.

Тайваньд Танакагийн меморандумыг үнэн бодит зүйл гэж үздэг түүгээр барахгүй тэрхүү меморандумыг хятадууд гартаа хэрхэн оруулж авсан бэ гэдгийг батлан үзүүлэхийг оролдсон нэгэн ном 1960 онд Тайваньд хэвлэгдсэн байна. Уг номонд өгүүлснээр, Цай-Чи-кан хэмээх японд төрсөн тайвань хүн бөгөөд бизнесийн ажлаар Япон, Манжуурын хооронд үргэлж ирж очдог байжээ. Цай нэг удаа Мүгдэнд өмнө өгүүлсэн Ван Зячэнтэй уулзаад ирсний дараа өөрийн танил японы улс төрийн зүтгэлтэн Токонами Такэзирогоор дамжуулан эзэн хааны ордны тамга баригч сайд Макинод ойртон итгэлийг олж чаджээ. Ийнхүү 1928 оны зургадугаар сарын нэгэн шөнө Макиногийн туслалцаатай эзэн хааны ордны номын санд нэвтрэн орж Танакагийн меморандумыг бүрэн эхээр нь хуулан авч чадсан аж. Цай дараа нь яаралтай Мүгдэнд ирж Ван Зячэнд уг меморандумыг гардуулан өгсөн гэжээ. Тэгтэл Ван Зячэнь гэгч хэн байв? Ван Зячэнь 1899 онд Жилинь мужид төрсөн, Японд удаан хугацаагаар суралцаад 1924 онд Аояма Гакуин Их сургуулийн эдийн засгийн факультетийг төгсчээ. Тэрбээр эхлээд Хятадын цэргийн эрхтэн У Пэйфу-гийн, дараа нь Жан Золинг нас барсны дараа түүний хүү Жан Сюэляны дэргэд ажиллах болжээ. Тэрбээр 1960 онд “Японы хоёр томоохон нууц баримтыг орчуулсан түүхээс” гэдэг дуртгалаа бичиж Бээжинд хэвлэгддэг “Түүхэн материалын цувралд” хэвлүүлжээ. Тэнд бичсэнээр 1928 оны сүүлчээр Токиод суудаг Жан Сюэляны төлөөлөгчөөс “Тайвань найз маань нэгэн улс төрийн намын удирдагчийн гэрээс маш чухал нууц бичиг баримтыг гартаа оруулж авсан гэсэн” мэдээ иржээ. Үүнд хоёр долоо хоногийн дотор 10 гаруй удаа илгээж ирүүлсэн бөгөөд Дайрэн хотод болсон Дорнодын асуудлаарх хурлын нууц протоколыг цэгцлэн бичсэн зүйл байжээ. Орчуулгын товчооноос япон хэлтэй 20 орчим хүнийг дайчилж хятад хэлэнд орчуулсан байна. Ваны бичсэнээр япон эх нь үг үсгийн алдаатай, үсэг дутуу газар ч их, уншиж ойлгоход төвөгтэй газар ч цөөнгүй байсан тул дахин редакторлахад их хөдөлмөр зарцуулсан гэжээ. Орчуулгыг 1929 оны хавар дуусгаж Жан Сюэлянаас зөвшөөрөл авсны дагуу 200 хувь хэвлүүлж, 120 хувийг засгийн газрын түшмэдэд тарааж, дөрвөн хувийг Нанжинд илгээн, бусдыг өөртөө авч үлджээ. Ван Зячэний дуртгалдаа бичсэн бүгдийг тэр чигээрээ үнэн бодит зүйл гэж хүлээн авч болохгүй нь мэдээж. Үүнээс Хата Икухито дүгнэлтийг хийсэн нь түүний дуртгалд гарч байгаа “Тайвань найз” гэдэг нь Цай бөгөөд уг

материалыг тэр үнэхээр худалдаж авсан байж магадгүй. Японы улс төрийн зүтгэлтэн гэдэг нь Сэйюкай намын дарга байгаад 1927 оны зургадугаар сард Минсэйто намд шилжсэн Токонами Такэзиро мөн байж магадгүй. Түүний гэрт Танакагийн меморандум хадгалагдаж байж таарахгүй бөгөөд харин Дорнод хязгаарын хуралтай холбогдолтой хэсэг бусад материал байсан байж магадгүй. Тэдгээр материалыг Мүгдэнд авчирсны дараа меморандум хэлбэрт оруулж бичсэн нь Ван Зячэнь болж таарч байна. Тиймээс ч Ван албан хэрэгцээнд ашиглахаар нэг хэсгийг түшмэд нарт тараагаад нөгөө хэсгийг гэртээ дарж байжээ. Энэхүү дуулиан болсон Танакагийн нэрээр нэрлэгдсэн меморандум нийт 40 мянган ханз үсгээс бүрдсэн үндсэн хэсэгтэйгээс гадна эзэн хааны ордны тамга баригч сайдад хаягласан нэгэн дагавар захианаас бас бүрдэнэ.

Танакагийн меморандумын тухай Японд анх 1929 оны 9 дүгээр сард олж мэдсэн байна. Бээжинд суугаа Японы түр хамаарагчаас 9 дүгээр сарын 16-нд цахилгаан ирсэн ба энэ мэдээнд тухайн оны 10-11 сард Киотод болох Номхон далайн асуудлаарх бага хуралд оролцох хятадын төлөөлөгчид Танакагийн меморандум гэгчийн хятад, англи дээрх орчуулгыг авчирч, дэлхийн олон нийтийн анхаарлыг татахаар төлөвлөж буйг мэдэгдсэн байна. Мөн хятад хэл дээр Нанжины “Шиши юэбао” сэтгүүлийн 1929 оны 12 дугаар сарын дугаарт хэвлэгдсэн байна. Үүнээс хойш хятадын олон сонин сэтгүүлд гарсан төдийгүй тусдаа товхимол болон хэвлэгдэж өргөнөөр тархжээ. 1931 оны 9 дүгээр сарын дугаарт англи хэлээр “Чайна Критик” сэтгүүлд хэвлэгдсэн байна. 1930 оны 6 дугаар сард Хятад-Японы клубээс уг меморандумыг “Манжуур-Монголын талаарх Японы бодлогыг хятад хүний нүдээр харахад” гэсэн гарчигтай япон хэл дээр хэвлүүлжээ.

Одоо харин Меморандумын товч агуулгыг өгүүлье.

“Манжуур-Монголд явуулах улс төрийн бодит бодлого

Манжуур, монгол гэдэгт Фынтянь, Гирин, Хэйлунзян муж мөн түүнчлэн Гадаад, Дотоод Монгол орж байгаа юм. Энэ орон нь уудам газар нутаг, хүн амын сийрэг суурьшлаараа төдийгүй дэлхийд хаана ч байхгүй ой модны баялаг, эрдэнэсийн нөөц, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн арвинаараа анхаарал татаж байгаа юм. Өмнөд манжуурын төмөр замын компанийг байгуулж энэ бүсэд төмөр зам, хөлөг онгоц зорчилт, уул уурхай, ой мод, төмрийн хүдэр, хөдөө аж ахуй, мал аж ахуйн үйлдвэрүүдэд 440 сая иений хөрөнгө орууллаа. Харин хятадыг байлдан дагуулахын тулд эхлээд Манжуур, Монголыг байлдан эзлэх хэрэгтэй. Дэлхийг байлдан дагуулахын тулд эхлээд хятадыг байлдан эзлвэл зохино. Нэгэнт хятадыг эзэлж чадвал бага Азийн бусад бүх орон, Энэтхэг, мөн түүнчлэн Өмнөд тэнгисийн бүх орон биднээс эмээж бууж өгцгөөх болно. Тэр үед дэлхий дахин Дорнод

Ази манайх боллоо гэдгийг ойлгож бидний эрх дархтай арцалдаж эс зүрхлэнэ. Бидэнд эзэн хаан Мэйжигийн гэрээслэн өвлүүлсэн төлөвлөгөө ийм бөгөөд түүний амжилт нь манай Японы эзэнт гүрэн оршин тогтноход нэн ач холбогдолтой байх болно.

- Дотоод болон Гадаад Монголд явуулах бодит бодлого

Түшээтэд япон цэргийн арван есөн огцорсон дарга сууж байгаа ба тэндээс бид ноос, газар худалдан авах, уул уурхайн баялаг эзэмших бүрэн эрхтэй болсон. Бид нууц байдлаар, огцорсон цэргийн дарга нарыг улам олноор нь тийшээ илгээх болно. Мүгдэнгийн засгийн газарт хар авахуулахгүйн тулд тэд хятад маягаар хувцаслах ёстой. Нутаг нутагт нь гаран сууж газар тариалан, мал аж ахуй эрхэлж ноос ноолуур худалдан авах ажил хийнэ. Ингэснээр, Гадаад, Дотоод Монгол биднийх болно.

- Солонгос иргэдийн цагаачлалыг хөхиүлэн хамгаална

Эдүгээ зүүн гурван мужид сая гаруй солонгос аж төрөн сууж байгаа. Тэдний тоо хоёр сая хагасаас давах үед хэрэгцээ тохиолдвол солонгосын хөдөлгөөнийг дарах нэрээр цэрэг дайны үйл ажиллагаанд татан оролцуулж тэднийг дэмжих болно. Солонгосчуудын хүчээр манжуур, монголын баялгийг ашиглан хөгжүүлж худалдааны давуу эрхийг гартаа оруулж авна. Эдгээр нутаг оронд солонгосуудыг оруулах нь эдийн засаг, цэрэг дайны асар их ач холбогдолтой учраас эзэн хааны засгийн газар үүнийг дэмжихгүй байхын аргагүй. Энэ бүхэн нь манай эзэнт ёсыг хөгжүүлэх шинэ ирээдүйг нээж байгаа юм.

- Манай шинэ тивийн хөгжил ба Манжуур, Монгол дахь төмөр зам

Өмнөд Манжуурын төмөр замыг голчлон эдийн засгийн зорилгоор тавьсан юм. Иймд хятадууд төмөр зам байгуулах чухамхүү бидний ажлыг дэмжих ёстой. Гэхдээ улаан оросын хүч чадал нь саарч байгаа хэдий ч Манжуур, Монголд нэвтрэн орох төлөвлөгөөнөөс ухраагүй байгаа. Энэ чиглэлээр хийх тэдний алхам бүр нь Өмнөд Манжуурын төмөр замын талаархи манай ашиг сонирхол, чиг зорилгод саад болохгүй гэхийн үндэс байхгүй. Иймд улаан орос тийшээ нэвтрэх явдлыг байдаг хүчээрээ саатуулах ёстой. Улаан орос өмнө зүг рүү нэвтрэн орох гэж байна гэдэг халхавчийн дор бид Хойт Манжуур руу орох явдлаа аажмаар эрчимжүүлж энэ бүсийн баялаг нөөцийг эзлэн авч умартад өмнөөс хятад нэвтрэхийг саатуулж, умартаас улаан орос урагшаа орох явдлыг гаргуулахгүй байвал зохино.

- Чанчунь-Таонанийн төмөр зам

Манжуур-Монголын баялаг хойт Манжуурт төвлөрч байгаа учраас тэр замыг гартаа оруулснаар Хот Манжуур, Монголын баялгийг эзэмших болно. Манай 200-300 мянган цагаачдыг тэр замын дагуу суурьшуулах болно. Дуньхуаны төмөр замыг гүйцээж, Хуэйлиниэс Солонгос руу ордог шугамтай холбосон цагт Монгол, хойт Манжуурын түүхий эдийг Осака, Токио руу шууд аваачна.

- Гирин-Хуэйлиний төмөр зам

Энэ замыг барьснаар европ явах хүмүүс Дайрэн юм уу Владивостокоор дамждагаа больж Сэйсин боомтоос Хойрэнийг дайрч дорнод сибирийн төмөр замаар зорчдог болно. Энэ зам дорнод дахь хамгийн том гол судас болох ёстой. Ачаа бараа, зорчигчид яалт ч үгүй манай бүс нутгийг дайран гарах болно. Ийм үед бид асар урт зам харилцааны тогтолцоог гартаа оруулж эзэн хаан Мэйжигийн төлөвлөгөөний гурав дахь шатны зорилгоос үүдсэн Манжуур, Монголыг хүч түрэн авах манай санаархлыг нуухын хэрэггүй болно. Ямато угсаатан дэлхийг байлдан эзлэх замд орж чадна.

- Уул уурхай, газрын баялаг

Япон орон далайн учраас газрын болоод уул уурхайн баялаггүй японы хувьд Манжуур-Монголын нутаг дахь төмөр ба ган, газрын тос, аммоний сульфат болон хөдөө аж ахуйн бусад бордоо, натри болон кальцжуулсан сод, магнит ба хөнгөн цагаан гэх мэт баялаг нь бидний үндэсний хөгжил, эдийн засгийн эрх ашгийн гол зүрх болж байна.

- Колонийн хэргийн яам байгуулах

Бид ажлынхаа арга барилыг өөрчлөх хэрэгтэй. Хяналтын төвийг Токиод шилжүүлбэл зохино. Ингэх нь 1. нууцыг хадгална, 2. манай төлөвлөгөөг хятадууд урьдчилан мэдэхээс сэргийлнэ, 3. төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө бусад гүрнүүд хардаж сэрдэх явдлаас ангижруулна, 4. Манжуур, Монголд тавьдаг дөрвөлсөн хяналтыг арилгана, 5. төв засгийн газрыг Манжуур, Монголтой нягт холбон өгч хятадад бүх хүч анхаарлаа төвлөрүүлэх боломжийг хангана. Бид Манжуур-Монголд нэвтрэн орох үйл ажиллагааг удирдуулахын тулд колоний хэрэг эрхлэх яамыг байгуулах хэрэгтэй болж байна” гэжээ.

Монгол судлаачийн үзсэнээр “Меморандум нь Дорнодын асуудлаарх хурлын материалыг меморандум хэлбэрт оруулан зохиожээ гэсэн дүгнэлт хийх үндэслэл их байна” гэжээ. “Танакагийн меморандум” гэгч энэхүү дуулиан болсон зүйл нь өнөөг хүртэл эх хувиараа олдоогүй нь “меморандум” зохиомол зүйл гэдэгтэй үнэнд ойртож байна. Дээрх таамгуудаас япон хүн зохиосон уу хятад хүн зохиосон уу эсвэл япон хүн анх зохиогоод хятад хүнд худалдсан уу гэдэг дээр нарийн судалгаа хийх шаардлагатай гэж үзэж байна. Харин меморандум хэлбэрт оруулсан Дорнодын асуудлаарх хурлын материал гэж үзэх юм бол агуулга нь тэр үеийн Японы түүхэн үйл явц, улс төрийн бодлого, эдийн засгийн зорилготой бодитой нийцэж байна. Японы бодлого Манжуур-Монголд нэвтэрч цаашлаад Орос руу чиглэгдэж байсан нь 1939 оны түүхэн үйл явдал болох Халх голын дайн уг бодлогын бодитойг баталж байна. Мөн тэдний эдийн засгаа хөгжүүлэх зорилгын тэргүүлэх чиглэлүүд төмөр зам, телеграф, усан боомт, уул уурхай, нэхмэл, ган төмөр зэрэг салбарууд байсан нь мөн дээрх меморандумын агуулгатай нийцэж

байна. Танакагийн меморандум зохиомол юм бол ямар зорилгоор ямар хүн зохиов гэсэн асуудал зүй ёсоор гарах нь мэдээж. япон хүн зохиосон гэхээсээ илүү хятад хүн зохиосон гэвэл илүү магадлал өндөртөй. Яагаад гэвэл Милитарист бодлого явуулж байсан Японоос болгоомжилж улс оронд сэрэмжлүүлэг өгөх үүднээс зориуд зохиосон гэж үзэж болох юм. Танакагийн меморандум мэтийн зохиомол төлөвлөгөө Хятадад нэг биш удаа гарч байсан нь ийм дүгнэлт хийхэд хүргэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Ц.Батбаяр. “Монгол ба Япон XX зууны эхэн хагаст”, УБ, 1998
2. Баабар “XX зууны монгол: нүүдэл суудал”, УБ, 2004
3. <http://www.pressinst.org.mn>
4. <http://ja.wikipedia.org/wiki/>